

## ТАНИЛЦУУЛГА

“Хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулсан тухай

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэлэлцэн баталж, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт “Нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоо нь ... аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын газар, сум, дүүргийн тасаг, нийгмийн даатгалын байцаагч, ажилтнаас бүрдэнэ” гэж, 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэгт “Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Эрүүл мэндийн магадлалын зөвлөл, .... шийдвэрлэх зөвлөлтэй байна” гэж тус тус зааснаар аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь нийгмийн даатгалын газар, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс нь Эрүүл мэндийн магадлалын зөвлөл болон өөрчлөгдсөн.

Хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Засгийн газрын хуралдаанаар Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай 15 дугаар тогтоолыг баталсан. Уг тогтоолоор “аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс” гэснийг “аймгийн Нийгмийн даатгалын газар” гэж өөрчилсөн.

Мөн Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 43 дугаар зүйлийн 43.4-т “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм, энэ хуулийн 43.3-т заасан цагийн хөлсний хэмжээг Засгийн газар батална” гэж заасны дагуу Засгийн газрын 2023 оны 12 дугаар 13-ны өдрийн “Дүрэм батлах тухай” 448 дугаар тогтоолын хавсралтаар “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм”-ийг баталсан. Тус дүрмийн 2.10-т “Аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн дарга нь аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга байна” гэж заасан.

Дээрх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газрын “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 487 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт”-д нэмэлт, өөрчлөлт оруулахаар тогтоолын төсөлд тусгав.

Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны 2024 оны төсвийг 55.3 тэрбум төгрөгөөр баталсан бөгөөд үүнээс цалин хөлс, нэмэгдэл, урамшуулалд 39.5 тэрбум төгрөгийг баталсан.

Энэхүү тогтоол батлагдсанаар дээрх батлагдсан үйл ажиллагааны зардлын төсөвт багтаан хэрэгжүүлэх боломжтой юм.

Мөн Засгийн газрын 2017 оны “Агентлаг байгуулах тухай” 344 дүгээр тогтоолоор Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрыг өөрчлөн зохион байгуулж Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрыг шинээр байгуулж, Эрүүл мэндийн сайдын эрхлэх хүрээний Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байхаар баталсан бөгөөд Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоолоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын орон тооны хязгаарыг 82 байхаар өөрчлөн тогтоосон.

Дээрх орон тооны хязгаар батлагдсанаас хойш дараах эрх зүйн үр дагавар үүссэн хэдий ч Нийгмийн даатгалын ерөнхий газрын орон тоо хэвээр мөрдөгдөж байна:

1.Улсын Их Хурлаас 2022 онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг баталж хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор Засгийн газрын агентлагийг дэд буюу орлогч даргатай байхыг хориглосны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын орон тооноос дэд даргын орон тоо хасагдсан.

2.Засгийн газрын тохируулагч агентлаг болох Мэргэжлийн хяналтын ерөнхий газар татан буугдсантай холбоотойгоор Нийгмийн даатгалын төв болон орон нутгийн байгууллагуудад нийт 37 албан хаагч шилжин ирж ажиллаж байна. Үүнээс 33 албан хаагч 21 аймаг, 6 дүүрэгт, 4 албан хаагч Нийгмийн даатгалын ерөнхий газарт хуваарилагдан ажиллаж байна.

3.Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэгт Маргаан хянан шийдвэрлэх төв зөвлөлийн нарийн бичгийн дарга орон тооны байх бөгөөд нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүтцэд хамаарахаар заасан тул уг заалтыг 2024 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөх шаардлагатай болсон.

Иймд Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2017 онд батлагдсан 82 орон тооноос 1 орон тоо хасагдаж, Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас 4 орон тоо шилжиж ирсэн, Маргаан хянан шийдвэрлэх төв зөвлөлийн нарийн бичгийн даргын орон тоо бий болсон учраас тус агентлагийн орон тоог 86 болгож шинэчлэн батлах шаардлага бий болсон.

Мөн Улсын Их Хурлаас 2017 онд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж малчинд тэтгэвэр тогтоох болон тэтгэврийн насыг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах журмыг Засгийн газар батлахаар тусгасны дагуу Засгийн газраас 2018 оны “Журам батлах тухай” 71 дүгээр тогтоолыг батлан, мөрдөж байсан болно.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 71 дүгээр тогтоолыг хүчингүй болгохоор тусгасан болно.

Иймд дээрх хууль тогтоомжид нийцүүлэн “Хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгын хамт боловсрууллаа.

Энэхүү тогтоол батлагдсанаар нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны болон улсын төсөвт нэмэлт хөрөнгө шаардагдахгүй болно.

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ**

**Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**

“Засгийн газар бүрэн эрхийнхээ асуудлаар хуралдаанаас тогтоол, нэг удаагийн чанартай буюу шуурхай асуудлаар Ерөнхий сайд захирамж гаргана”

**Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг:**

“Энэ хуулийн 10.1.2, 10.1.4-т заасан удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаалын төрөлд хамаарах албан тушаалын жагсаалтыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална”

**18 дугаар зүйлийн 18.8 дахь хэсэг:**

“Яам, төрийн бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно”

**Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг:**

“Агентлагийн орон тооны дээд хязгаарыг Засгийн газар, агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр болон зохион байгуулалтын бүтцийг Засгийн газраас тогтоосон ерөнхий загварыг баримтлан Монгол Улсын сайд батална”

**Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэг:**

“Төв зөвлөлийн нарийн бичгийн дарга орон тооны байх бөгөөд нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүтцэд хамаарна” гэж тус тус заасан болно.